



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/93/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
БиГГ	Гаалийн ерөнхий газрын харьяа Сүхбаатар аймгийн Бичигт дэх Гаалийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН
ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ЦЭЦЭГДЭЛГЭР ТАНАА

2023.02.25 № 115

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 6 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 34 арга хэмжээ биелэгдэж, 91.8 хувьтай биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

2022 оны төлөвлөгөө нь 1,298,926.9 мянган төгрөг, гүйцэтгэл нь 1,228,243.1 мянган төгрөг 94.56 хувьтай байна. Улсын төсвөөс гүйцэтгэлээр 1,228,243.1 мянга, орон нутгийн төсвөөс 151,036.7 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 9,557.1 мянган төгрөгний санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,313,305.4 мянган төгрөгийг зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл

D:/Bichig hereg/2023/A4 toot

ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>82,464,433.62</u>	<u>140,848,907.84</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	70,683,464.06
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	70,683,464.06
3121	Төгрөг	-	70,683,464.06
31211	Төрийн сангийн харилцах	-	70,683,464.06
35	БАРАА МАТЕРИАЛ	82,464,433.62	70,165,443.78
354	Хангамжийн материал	66,406,766.12	47,350,503.12
35410	Бичиг хэргийн материал	1,564,150.00	1,942,500.00
35420	Аж ахуйн материал	63,115,558.87	43,930,903.12
35440	Түлш, шатах тослох материал	849,807.25	-
35460	Хүнсний материал	547,150.00	806,000.00
35470	Бусад хангамжийн материал	330,100.00	671,100.00
35500	Биологийн хөрөнгө	6,591,667.50	12,534,940.66
35600	Мал амьтад	9,466,000.00	10,280,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,470,967,167.00</u>	<u>1,463,529,255.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,470,967,167.00	1,463,529,255.09
392	Биет хөрөнгө	1,437,155,167.00	1,428,267,255.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,512,579,525.00	1,512,579,525.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(158,193,587.72)	(253,864,858.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,560,000.00	14,560,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,560,000.00)	(14,560,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,213,712.47	260,614,983.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(145,598,310.91)	(159,239,287.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,785,665.02	99,610,665.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(71,548,507.52)	(76,651,610.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,000,000.00	9,209,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,366,666.82)	(6,796,666.86)
39217	Ном	39,283,337.48	42,805,504.48
393	Биет бус хөрөнгө	33,812,000.00	35,262,000.00
39301	Програм хангамж	500,000.00	2,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	33,812,000.00	33,812,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,553,431,600.62</u>	<u>1,604,378,162.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,004,940.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,004,940.00
413	Өглөг	-	1,004,940.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,004,940.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,553,431,600.62</u>	<u>1,603,373,222.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,553,431,600.62	1,603,373,222.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,119,717,908.98	1,119,717,908.98
51101	Өмч: - төрийн		
51102	- хувийн	1,119,717,908.98	1,119,717,908.98

512	Хуримтлагдсан үр дүн	64,970,794.74	114,912,417.05
51210	Өмнөх үеийн үр дүн	85,509,219.06	(1,488,460,805.88)
51220	Тайлант үеийн үр дүн	(20,538,424.32)	1,603,373,222.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	368,742,896.90	368,742,896.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,553,431,600.62	1,604,378,162.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,006,013,675.52	3,054,038,230.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,772,855.52	1,633,482,030.68
120	Нийтлэг татварын бус орлого	26,772,855.52	1,633,482,030.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,772,855.52	1,633,482,030.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,057,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,772,855.52	1,623,924,930.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	979,240,820.00	1,420,556,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	883,357,700.00	1,289,369,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,289,369,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	883,357,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,968,320.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	733,920.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,234,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,914,800.00	131,186,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,914,800.00	131,186,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,026,552,099.84	1,450,665,007.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,026,552,099.84	1,450,665,007.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	985,570,193.03	1,370,446,622.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,817,078.44	917,519,062.94
210101	Үндсэн цалин	457,946,578.61	642,974,177.02
210102	Нэмэгдэл	178,456,400.69	200,986,567.02
210104	Урамшуулал	65,414,099.14	73,558,318.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,293,200.00	120,988,900.00
210201	Тэтгэврийн даатгал	66,606,500.00	82,229,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,132,200.00	9,678,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,114,700.00	7,743,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,226,700.00	1,979,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,213,100.00	19,358,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,827,219.50	74,997,021.73
210301	Гэрэл, цахилгаан	11,614,494.75	21,408,693.48
210302	Түлш, халаалт	54,262,804.75	43,350,828.25
210303	Цэвэр, бохир ус	7,949,920.00	10,237,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,746,666.00	-
210401	Бичиг хэрэг	1,004,066.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,216,600.00	-

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	943,900.00	-
210404	Ном, хэвлэл	2,432,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	283,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,866,200.00	-
2105	Нормативт зардал	27,433,550.00	60,003,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	462,800.00	-
210502	Хоол, хүнс	26,970,750.00	60,003,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,695,960.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,695,960.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,202,632.00	13,177,602.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,202,632.00	5,057,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,120,502.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,553,887.09	178,761,035.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,971,200.00	48,587,495.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,178,450.00	14,278,190.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,404,237.09	115,895,349.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,981,906.81	80,218,385.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,443,900.00	80,136,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,293,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,150,900.00	80,136,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	82,385.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	82,385.52
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,538,006.81	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,538,006.81	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,538,424.32)	1,603,373,222.93
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(20,538,424.32)	1,603,373,222.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	979,240,820.00	1,430,113,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,557,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	9,557,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	9,557,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,057,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	979,240,820.00	1,420,556,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	883,357,700.00	1,289,369,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,289,369,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	883,357,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,968,320.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	733,920.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,234,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,914,800.00	131,186,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,914,800.00	131,186,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	969,398,720.00	1,313,305,454.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	969,398,720.00	1,313,305,454.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	928,236,713.19	1,232,746,069.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,817,078.44	917,519,062.94
210101	Үндсэн цалин	457,946,578.61	640,741,407.02
210102	Нэмэгдэл	178,456,400.69	200,986,567.02
210104	Урамшуулал	65,414,099.14	75,791,088.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,293,200.00	120,988,900.00
210201	Тэтгэврийн даатгал	66,606,500.00	82,272,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,132,200.00	9,678,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,114,700.00	7,743,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,226,700.00	1,935,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,213,100.00	19,358,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,113,026.75	74,147,214.48
210301	Гэрэл, цахилгаан	11,614,494.75	21,408,693.48
210302	Түлш, халаалт	54,548,612.00	42,501,021.00
210303	Цэвэр, бохир ус	7,949,920.00	10,237,500.00
2105	Нормативт зардал	29,357,700.00	59,589,300.00
210502	Хоол, хүнс	27,667,900.00	59,589,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,679,860.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	7,509,960.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,997,732.00	13,177,602.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,997,732.00	5,057,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,120,502.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,463,950.00	42,323,990.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	27,891,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,463,950.00	14,432,190.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,162,006.81	80,559,385.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,624,000.00	80,477,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,293,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,331,000.00	80,477,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	82,385.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	82,385.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,538,006.81	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,538,006.81	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,842,100.00	116,807,845.06
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	46,124,381.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	46,124,381.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	46,124,381.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	46,124,381.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(46,124,381.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,842,100.00	70,683,464.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	70,683,464.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,119,717,908.98	368,742,896.90	85,509,219.06	1,573,970,024.94
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	85,509,219.06	1,573,970,024.94
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-20,538,424.32	-20,538,424.32
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	64,970,794.74	1,553,431,600.62
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	64,970,794.74	1,553,431,600.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,553,431,600.62	-1,553,431,600.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	-1,488,460,805.88	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,603,373,222.93	1,603,373,222.93
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,119,717,908.98	368,742,896.90	114,912,417.05	1,603,373,222.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,449,963,300.00	1,359,347,450.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,449,963,300.00	1,359,347,450.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,359,143,700.00	1,278,870,450.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	977,411,300.00	917,519,062.94
210101	Үндсэн цалин	733,875,200.00	640,741,407.02
210102	Нэмэгдэл	218,574,000.00	200,986,567.02
210104	Урамшуулал	24,962,100.00	75,791,088.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,988,900.00	120,988,900.00
210201	Тэтгэврийн даатгал	82,272,500.00	82,272,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,678,900.00	9,678,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,743,400.00	7,743,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,935,900.00	1,935,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,358,200.00	19,358,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,079,600.00	74,147,214.48

210301	Гэрэл, цахилгаан	16,500,000.00	21,408,693.48
210302	Түлш, халаалт	54,200,000.00	42,501,021.00
210303	Цэвэр, бохир ус	23,379,600.00	10,237,500.00
2105	Нормативт зардал	59,589,300.00	59,589,300.00
210502	Хоол, хүнс	59,589,300.00	59,589,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,678,600.00	14,677,602.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,057,100.00	5,057,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,621,500.00	9,620,502.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,396,000.00	83,948,371.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,963,800.00	69,516,181.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,432,200.00	14,432,190.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,819,600.00	80,477,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,819,600.00	80,477,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,819,600.00	80,477,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,440,406,200.00	1,420,556,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,440,406,200.00	1,420,556,200.00
122005	Орон нутгийн төсвөөс	1,440,406,200.00	1,420,556,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын үйл ажиллагаа явуулдаг БШУ-ны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг нь төрийн үйлчилгээний байгууллага бөгөөд суралцагчдын сурлагын болон сурах арга барилыг сургаалтанд нэвтрүүлэх зорилготой.

Сурагчдын агуулгын болон сурах арга барилын хоцрогдлыг оношлох, сургуулийн цахим хичээлийн санг баяжуулж, суралцагчдын цахимаар суралцах боломжийг нэмэгдүүлэх, агуулгын хоцрогдлыг бууруулж, гүйцэтгэлийг 25 хувиар ахиулах, хүүхдийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай суралцах, хөгжихөд нь тасралтгүй дэмжлэг үзүүлэх, багшийн хандлага, хувь хүний хөгжил, арга зүй, мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлээр хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 3 сарын 9-ний өдрийн 107 тоот тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- БШУ-ны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/122 тоот тушаал “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа улсын секторын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,946.5 мянган төгрөгөөр буюу 3.28 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	70,683.46	70,683.46
Авлага	-	-	-
Бараа материал	82,464.43	70,165.44	(12,298.99)
Үндсэн хөрөнгө	1,470,967.17	1,463,529.26	(7,437.91)
Нийт хөрөнгө	1,553,431.60	1,604,378.16	50,946.56
Өр төлбөр	-	1,004.94	1,004.94
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,553,431.60	1,603,373.22	49,941.62
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,553,431.60	1,604,378.16	50,946.56

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,463,529.3 мянган төгрөг болж, 7,437.9 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурч, бараа материалын үлдэгдэл 70,165.4 мянган төгрөг болж 12,298.9 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,048,024.5 мянган төгрөг буюу 203.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Тухайн өсөлт нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой үнэ төлбөргүй хүлээн авсан 1,533,300.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 90,624.7 мянган төгрөгийн бараа материалын орлогоос, мөн санхүүжилтийн орлого 441,315.4 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 424,112.9 мянган төгрөгөөр буюу 41.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл цалин, бусад бараа үйлчилгээний нормативт зардал өссөн болон үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Цалингийн зардал 215,702.0 мянган төгрөгөөр, хүүхдийн хоол хүнсний зардал 33,032.2 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,298,926.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 151,036.7 мянган төгрөг, нийт зарлагыг 1,449,963.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,449,963.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,359,429.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд 1 хөтөлбөр 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 97 хувийн гүйцэтгэлтэй байна.

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	3,848.60	3,848.60	-	100%
2	80312	Сургалт семинар	1,924.30	1,924.30	-	100%
3	81605	Эрүүл мэндийг дэмжих	4,425.90	4,425.90	-	100%
4	81801	Үдийн цай хөтөлбөр	90,819.60	80,477.00	10,342.60	89%
5	81806	Дотуур байрны үйлчилгээ	77,389.40	77,389.40	-	100%
6	81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	41,960.00	41,514.30	445.70	99%
7	81823	Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр	8,659.30	8,657.30	2.00	100%
8	81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөтөлбөр	957,084.50	899,094.10	57,990.40	94%
9	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	103,257.90	101,355.00	1,902.90	98%
10	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	4,000.00	4,000.00	-	100%
11	81848	Сурах бичгийн түрээс	5,057.10	5,057.10	-	100%
12	83602	ЗГ болон засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан	500.00	500.00	-	100%
13	80112	Нийтлэг үйлчилгээ	51,957.10	51,957.10	-	100%
14	80111	Байр ашиглалтын үйлчилгээ	99,079.60	79,229.60	19,850.00	80%
			1,449,963.30	1,359,429.70	90,533.60	97%

Батлагдсан төсөв гүйцэтгэлийн зөрүү 90,533.6 мянган төгрөг байна. Үүний 70,683.5 мянган төгрөг нь зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл бол 19,850.1 мянган төгрөг олгогдоогүй санхүүжилтийн дүн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 9,557.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн, зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ны /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах М.Уламбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 10,265.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,185.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд бараа үйлчилгээний зардал өссөн байна. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой байна. Нийт батлагдсан төсвөөс 70,683.5 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан нь дансны үлдэгдлийн баталгаагаар нотлогдож байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 102 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн, 11 мэдээллийг хугацаа хоцроосон, 6 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургуульд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай биелсэн байна.

Элэгдлээрээ өртгөө нөхсөн 141 нэр төрлийн үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авч данснаас хасах зөвлөмж өгсөн. Актлаж, данснаас хасах саналыг аймгийн ОНӨГ-т хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	50
Нийт дүн	2		2		50

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар аливаа акт, албан шаардлага хүргүүлэх асуудлууд илрээгүй бөгөөд байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 1 зөвлөмжийг хүргүүллээ.

5.1 Зөвлөмж

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нийт 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулахаас 102 мэдээллийг хугацаандаа мэдээллэсэн, 11 мэдээллийг хугацаа хоцроосон, 6 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан хугацаанд мэдээлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	
Дүн	1	-	-	-	-	-	1	-